

АЖ ТОРОХ
УХААН

Г.Ловор

ЁС ЗАНШИЛ ИДЭЭ ШҮҮС



II
ангийнханд
зориулав

Г.Ловор
Ёс заншил идээ шүүс

Бага сургуулийн 2-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах Д.Сугархүү
Хянан тохиолдуулагч	О.Мөнхтуяа
Хянагч	Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Н.Хөдөлмөр Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

ЁС ЗАНШИЛ, ИДЭЭ ШҮҮС

Аливаа улс үндэстний хүндэтгэлийн идээ шүүс өөр өөр. Монголчууд хонины бүхэл бүтэн шүүс тавьж хүндэтгэлээ илэрхийлнэ. Оросууд эрхэм зочноо талх давс барьж угтдаг.

Тэрхүү идээ зоогийг таваглах, зооглох нарийн горим дүрэмтэй.



Таваг, царанд ууцны урд доор нь өвчүү, хүзүү, сээр, хоёр хаагий нь ивнэ. Хойд доор нь хоёр хөл шаантыг нь урагш хандуулан хэвтэж буй хонь шиг байрлуулан дээр нь толгойг нь тавина.

Эхлээд дух, ууц, сүүлний толионоос халимлан авч галд, тэнгэрт өргөөд, дараа нь сээр, хүзүү болон бусад махнаас гар хүрч амсана.



Хэрэв ууцыг таллах болбол сүүл талыг өөр лүүгээ хандуулна. Ууцны хоёр хажуугаас ээлжлэн нимгэвтэр зүсэж, хүн бүхэнд хүртээнэ. Тэгэхдээ найр наадам, баяр цэнгээн болгонд ууц тавьдаггүй, онцгой хүндтэй

зочин, хурим найрт зоог болгон бүхэл шүүс тавьж ёсолдог байжээ.

Буриадын зарим хуримын үед:
Хониныхоо дэргэдүүр
"Хоолбой" гэж гараарай
Хов живийн хооронд
Хойшоо сугаран үлдээрэй... гэхчлэн сургамж бүхий
"Ууцын дуу" дуулдаг байв.



Ер нь хонины мах хүндэтгэлийн зэрэгтэй учраас зочин гийчний өмнө тавьсан зоогоор тэр ямар зиндааны зочин болохыг мэдэж болно гэдэг.

Эрхэм хүндтэй аав ээж, авга, нагац ах юм уу, эсвэл дээд албаны хүнийг хүндэлж ууц тавина.

Жирийн цагт аав, авга, ахмад настанд дал дөрвөн өндөр, ээж, нагац эгчдээ сээр, нуруу, хонт шаант, өвчүү чанаж өгөх нь түгээмэл.



Харин хүзүү, богтос өгдөггүй, ихэвчлэн өөрсдөө хүүхэд багачуудтайгаа идэх нь элбэг.

Малд шалиг буюу цээр мах гэж бий.

“Тэнэг түрүү идвэл эргүү болно. Тархи идвэл улцан болно. Нугас идвэл нусгай болно. Булчирхай идвэл бузартана. Сархинаг идвэл салан болно” гэхчлэн хориглохоос гадна “Түгшүүр идвэл морь чинь түгшинэ. Бүдэрхий идвэл бүдэрнэ” гэх мэт элдэв цээр ч байдаг. Бас өнчин элэг, богино хавиргыг хэн ч иддэггүй ёстой ажээ.

Энэ мэт идээ, шүүс, хоол унд зооглохдоо баримталдаг монголчуудын ёс горим нь уламжлалт зан үйл, ардын билэг зүй, утга соёлын нэгээхэн хэсэг юм.

Бага сургуулийн 2-р ангийнханд зориулав.



Монголчуудын хот хүрээ гэдэг ойлголт юунаас үүссэн бэ?



Хот сууринд суугчдын өдөр тутмын мөрдөх нэг чухал хууль бол замын хөдөлгөөний дүрэм.



Малчдын ажиллах, амьдрах нөхцөлөөс ургаж гарсан таатай сууц.



Монголчуудын амьдралын гол хэрэглээ идээ шүүс, хоол ундаа цаг хугацаа, ёс горимтой зооглодог тухай.



Хүн төрөлхтөн өдөр тутмын мэдээлэл сонирхон олж авдгийн ачаар амьдрал ахуйгаа хөгжүүлэн зохицуулж, ирээдүйгээ төсөөлдөг.



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй "Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв. Худалдахыг хориглоно.